


НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ  
ХАРИУЦСАН НЭГДҮГЭЭР ОРЛОГЧ



Ж. БАТБАЯСГАЛАН

БАТЛАВ.

НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН ХӨГЖЛИЙН  
ГАЗРЫН ДАРГА



Ж. ТОГТОХБАЯР

**“НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ-1” -ИЙН ХҮРЭЭНД ЧИНГИСИЙН ӨРГӨН ЧӨЛӨӨНД  
ХҮҮХДИЙН ОРДОН, БАЯНГОЛ РЕСТОРАН ОРЧИМ ТУСГАЙ ЗАМЫН  
АВТОБУСНЫ БУУДАЛ ДЭЭР БАРИГДАХ ЯВГАН ЗОРЧИГЧИД ЗОРИУЛСАН  
ГҮҮРЭН (ЭСВЭЛ НҮХЭН) ГАРЦЫН ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ  
ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2019 оны 07 сарын 18 өдөр

Дугаар 34-19/080

Улаанбаатар хот

1. Зураг төсөл боловсруулах  
үндэслэл

1.1. Монгол улсын ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.224-р заалт “Улаанбаатар хотын авто замын ачааллыг бууруулах, түгжрэлийг багасгах зорилгоор гүүрэн гарцуудыг шинээр байгуулан, тусгай замын автобус /BRT/-ыг нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлнэ”.

1.2. Улсын Их Хурлын 2015 оны 4-р сарын 30-ны өдрийн чуулганаар хэлэлцэн баталсан “Улаанбаатар хотын нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр соёрхон батлах тухай” Монгол Улсын хууль;

1.3. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030”-ын 4-р зорилтын 2 дугаар үе шат (2021-2025);

1.4. “Монгол Улсын Засгийн газрын 2016 - 2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.224 дэх заалт;

1.5. “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020

оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.5.15 дахь заалт;

1.6. "Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.7 дахь заалт;

1.7. Улсын Их хурлаар 2015 оны 5-р сард соёрхон батлагдсан "Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн Засгийн газар нь Азийн хөгжлийн банкнаа үйл ажиллагаагаа 2017 оны 5-р сараас эхлүүлэн хэрэгжүүлж байна. Техник эдийн засгийн судалгааг 2012 онд боловсруулсан ба Улаанбаатар хот дахь сүүлийн 5-н жилийн хугацаанд гарсан өөрчлөлтүүдийг тусгахын тулд 2016 онд дахин шинэчилсэн.

1.8. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 7-р сарын ... өдрийн А/... дүгээр захирамж

1.9. НХТЕТГ-ын 2019 оны 3-р сарын 04-ний өдрийн МЗХ2019/04-01 тоот Авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар

2. Байршил

УБ, СБД, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Чингисийн өргөн чөлөө, Хүүхдийн ордны буудал

3. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр

Нийслэлийн 2019 оны төсөв

4. Гүүрийн техникийн ангилал, хүчин чадал

Явган зорчигчийн гүүрэн /эсвэл нүхэн/ гарц байх бөгөөд уртыг нь зураг төслийн шийдлээр тодорхойлно.

5. Гүүр /нүхэн гарц/-ийн бүтээц

Зураг төслийн шатанд тооцоог үндэслэнэ.

6. Зураг төсөл зохиох үе шат, хугацаа

1 үе шаттай, 2019 оны 3-р улирал

7. Төлөвлөлтийн норм

- "Авто замын гүүр ба хоолой" БНБД 32-02-12,
- "Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм" БНБД 30-01-04



- |    |                         |  |
|----|-------------------------|--|
| 8. | Захиалагч байгууллага   | Нийслэлийн Авто замын хөгжлийн газар   |
| 9. | Зураг төслийн иж бүрдэл | <ul style="list-style-type: none"> <li>• Инженер-геодезийн хайгуул судалгаа, байр зүйн зураглал</li> <li>• Инженер-геологийн хайгуул судалгаа</li> <li>• Буудлын урьдчилсан төлөвлөлт</li> <li>• Инженерийн нарийвчилсан зураг төсөл</li> <li>• Тайлбар бичиг /бат бэхийн тооцоо/</li> <li>• ИШС-ний холбогдох зураг төслүүд</li> <li>• Бүх зураг төслийн иж бүрэн төсөв</li> <li>• Барилгын ажлын техникийн шаардлага</li> <li>• Зураг төслийн ажлын магадлалын ерөнхий дүгнэлт</li> <li>• Азийн хөгжлийн банкны ерөнхий шаардлагыг хангасан барилгын ажлын тендерийн баримт бичиг</li> </ul> |

*Жич:*

*1. Зураг төслийн иж бүрдэл нь эдгээр заалтуудаар хязгаарлагдахгүй бөгөөд шаардлагын дагуу нэмэгдэж болно.*

*2. Иж бүрэн зураг төсөл гэж тухайн байгууламжийн ажлын зураг төсөл болон түүнийг дагалдах инженерийн шугам сүлжээний бүх зураг төслийг ойлгоно.*

10. Онцгой нөхцөл

Гүүр (эсвэл нүхэн гарц)-ийн зураг төслийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Авто замын гүүр ба хоолой” БНБД 32.02.12, “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30.01.04, “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” БД31.101.04, “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009, “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” БНБД 22.01.01 болон бусад холбогдох норм дүрэм, стандартуудыг үндэслэн зураг төслийг боловсруулах.

Гүүр (эсвэл нүхэн гарц)-ийг явган зорчигчид ТЗА-ны буудал руу саадгүй нэвтэрч орж гарч байхаар тооцож боловсруулах тул “Хүүхдийн ордон болон Баянгол ресторан” орчимд Чингисийн өргөн чөлөөнд баригдах буудлын төлөвлөлтийг хийнэ.

Явган зорчигчийн гүүр (эсвэл нүхэн гарц)-энд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгшид, хүүхдүүд, дугуйтай иргэд саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Гүүр (эсвэл нүхэн гарц)-ийг явган зорчигчийн хөдөлгөөний тооцоот ачаалал, газар хөдлөлтийн балл, зам – цаг уурын бүс, байгаль цаг уурын хүчин зүйлсийн үйлчлэл, газрын гадаргуун геологийн тогтоц, ус-дулааны горим гэх мэтчилэн бусад факторуудыг нарийвчлан тооцож төсөллөх.

Трассын дагууд хөрсний геотехникийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоож, инженер геологийн судалгааг нарийвчлан хийж, гүүрийн бүтээцийг оновчтой сонгох.

Гэрэлтүүлгийг архитектурын шийдэлтэй уялдуулан өнгө үзэмжтэй, гүүрийн зорчих хэсгийн үзэгдэх орчин, аюулгүй байдлыг хангасан байхаар оновчтой төлөвлөх.

Явган зорчигчийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан хайс, хашлага, авто машинаас тусгаарлах эд анги нарийвчлан тусгах.

Гүүр (эсвэл нүхэн гарц)-ийг барих зурваст орсон хөндөгдөж буй аливаа шугам сүлжээг эзэмшигч байгууллагатай зөвшилцөж, шаардлагатай тохиолдолд техникийн нөхцөл гаргуулж, ажлын зураг төсөл боловсруулж батлуулсан байх.

Гүүр (эсвэл нүхэн гарц)-ийн явган зорчигчийн хөдөлгөөн зохион байгуулалтыг аюулгүй байдлыг ханган улмаар зам, тээврийн ухаалаг системийн шаардлагад нийцүүлж төсөллөх.

Геодезийн байнгын цэг тэмдэгтийг БД 11-104-06 –г үндэслэн байгуулж, хүлээлгэн өгөх.

Зураг төслийг магадлалд оруулж баталгаажуулах.

Орчин үеийн дэвшилтэд арга технологийг тусгах.

Зураг төслийг дараах масштабээр боловсруулна. Үүнд:

- |                     |                              |
|---------------------|------------------------------|
| • Дэвсгэр зураг     | 1:500                        |
| • Дагуу огтлол      | хэвтээ 1:1000<br>босоо 1:100 |
| • Хөндлөн огтлол    | 1:100                        |
| • Уулзвар огтлолцол | 1:100                        |
| • Хучилтын бүтээц   | 1:20                         |
| • Хэсэглэл          | 1:10                         |

Зураг төслийг НАЗХГ, НГА, НХБХГ, Нийслэлийн Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газар болон Төсөл хэрэгжүүлэх нэгжтэй болон бусад холбогдох байгууллагуудтай зөвшилцөнө.

Авто зам, замын байгууламжийн ажлын зураг, тайлбар бичиг, инженер геологийн дүгнэлт, геодезийн ажлын тайлан, техникийн шаардлага, инженерийн шугам сүлжээний ажлын зураг, орчны



тоймыг харуулсан 3-н хэмжээст зураг, төслийн танилцуулга, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг зэрэг холбогдох баримт бичгүүдийг Азийн хөгжлийн банкны шаардлагад нийцүүлэн англи, монгол хэл дээр боловсруулах бөгөөд эх хувь 1 ширхэг, хуулбар хувь 3 ширхэг өнгөтөөр хэвлэн ирүүлнэ. Мөн цахим хэлбэрээр зураг төслийг pdf болон dwg өргөтгөлөөр ирүүлнэ.

#### Хянасан:

Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын  
орлогч дарга

Б.ИНДРА

“Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх  
хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл -1”-ийн  
зохицуулагч

А.ХҮРЭЛБАТ

Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын  
Бодлого зохицуулалтын хэлтсийн дарга

Р.БАТЦОЛМОН

#### Боловсруулсан:

Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын  
Бодлого зохицуулалтын хэлтсийн Гүүрийн  
төлөвлөлтийн мэргэжилтэн

М.ИЧИНХОРЛОО

Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын  
Бодлого зохицуулалтын хэлтсийн усны барилга  
байгууламжийн мэргэжилтэн

Б.ЕРТИС

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн  
Авто замын инженер

Б.АМАРАА

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн  
Тээврийн инженер

Ж.ДАВААСҮРЭН





**Таних тэмдэг**

Шинээр төлөвлөж явган хүний гүүрэн  
гарц /эсвэл нүхэн гарц/

**Хянасан:**

"Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын  
хөтөлбөр, төсөл -1"-ийн зохицуулагч  
НАЗХГ-ын Бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга

*[Signature]* /А.Хүрэлбат/  
*[Signature]* /Р.Батцолмон/

**Боловсруулсан:**

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн Авто замын инженер  
НАЗХГ-ын Бодлого, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

*[Signature]* /Б.Амараа/  
*[Signature]* /М.Ичинхорлоо/